



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 232

Улаанбаатар хот

Хорооны 2012 оны 344 дүгээр тогтоолоор
батлагдсан журамд нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 344 дүгээр тогтоолоор батлагдсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, хяналт тавих журам”-ын 2 дугаар зүйлд дараах агуулга бүхий 2.1.6¹ заалтыг нэмсүгэй.

2.1.6¹ “Сан нь улс орны онцгой нөхцөл байдлаас шалтгаалан энэ журмын 2.1.6 дахь заалтад заасан өөрийн хөрөнгийн 10 хувиас дээш хэмжээгээр нэг зээлдэгч /жижиг, дунд үйлдвэр эрхлэгч/-д батлан даалт гаргах нөхцөлд Сангийн удирдах зөвлөлийн тогтоолыг үндэслэн Хорооны дарга зөвшөөрөл олгож болно”.

2. Журамд нэмэлтийг оруулж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭГЧ
ДЭД ДАРГА



Э.БАТБОЛД